



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 13-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ”

Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 76.1, 80.2 дахь хэсгүүд болон “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд танхимаар зохион байгуулж, хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,

2.2 “Сүү” ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Зууны мэдээ сонин, “ТВ9” телевизийн эфир, компанийн болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хурлын зарыг олон нийтэд анх мэдээлсэн өдрөөс хойш 16 хоногийн дараа 2026 оны 04 сарын 02-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүргэлийг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр дуусталх хугацаанд “Сүү” ХК-ийн байранд, Хурал зохион байгуулагдах өдөр буюу 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 15:00 цаг хүртэл хугацаанд “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд тус тус баталсан маягтын дагуу цаасаар болон www.survey.suu.mn цахим хуудсаар цахим хэлбэрээр бүртгэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ийн хэлэлцэж буй асуудлаар “Санал хураалт”-ыг баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр болон www.survey.suu.mn цахим хуудсаар тодорхой өгөгдлийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд Санал авах сүүлчийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит хурлын санал хураалт зохион байгуулах үе шатын саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаагаар тогтоосугай.

7. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №1 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын дэгийг Хавсралт №2 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын зарын төслийг Хавсралт №3 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийн бүртгэл болон санал авах хуудасны загварыг Хавсралт №4 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолын төслийг Хавсралт №5 ёсоор, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-аас гарах шийдвэрийн төслийг Хавсралт №6 ёсоор тус тус баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдэд холбогдох баримт бичигтэй тус компанийн www.suu.mn цахим хуудсанд хандан эсвэл өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан танилцаж болохыг мэдэгдсүгэй.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Тунгалаг, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Т.Хулан, Д.Ану-Үжин, Б.Үенч нарыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар иргэн Т.Дамдинсүрэн, гишүүнээр иргэн Ц.Бор-Охин, хөндлөнгийн аудитор “Нексия Глобал Монголиа” аудит ХХК-ийн төлөөлөгч нарыг тус тус томилсугай.

11. Тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсгийг удирдлага болгон ажилласугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцогчийг цахим хуудсаар бүртгэх, хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программ хангамж бүхий, зохих ажлын туршлагатай мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР